

**Га.ШАРАВЖАМЦЫН НАЙРУУЛАЛ ДАХЬ  
ДОМГУУДЫН ТУХАЙ**

**Фү Рүнх\***

Агуулгын товч: Найрууллын түүвэр “Шанду Хэйбүн Гүртү Балгас”-т домог, үлгэр, зүүд мэтийн аман зохиолын элемент их хэрэглэгдэж байдаг. Баарин гүүр байгуулагдсан тухай домог, монголчууд хун галууг агнахаа больсон тухай домог, Тогоон-Төмөр хааны зүүд, далбаа хайрханы домог, хүй голын гүүрийн тухай сонин яриа, тостой тогооны ёгт үлгэр, “Ванбайн вангийн ордоны” тухай домог, могойн үлгэр, улаан эрээн хүзүүт ногоон могойн ёгт үлгэр, могой, барын бэлгийн эрхтэний домог, цагаан зааны домог, Чингисийн Энэтхэгийг дайран цохиогүй буцсан тухай домог гэх мэт арваад домог байгаа юм.

Эдгээр домог, үлгэр ярианууд нь их өргөн хэмжээний агуулга үзэл санааг агуулсан боловч ихэвчлэн үндэстэн угсаатны өөдлөл уруудал, бүлгэмдэл нягтралтай холбогдсон, хүн зоны сэтгэл зүрхний эмзэглэлийг тусгасан одоогийн нийгэм ахуйн хүнд нүсэр асуудал зэргээр хураангуйлж болно. Найруулал нь домгийн тухай олон эшлэл хэрэглэлтэй байж, тэдгээр домгуудын тухай эшлэл хэрэглэл нь найрууллын бичлэгийн арга хэлбэрийг баяжуулж, найруулал дахь ачаалагч бие нь дан ганц хэрэг үзэгдэлээс олон тал тийш хөгжиж, үлгэр түүх, домог яриа гэх мэтийн ачаалагч биеэр дамжин, өөрийн үзэл сэтгэлгээ илтгэсэн нь шинэ нэгэн туршич болсон бөгөөд домог, үлгэрүүд нь мөн ч зохиогчийн үзэл сэтгэлгээний илрүүлийн өвөрмөц онцлог шинж болсон байна.

Түлхүүр үг: Га.Шаравжамц, найруулал, “Шанду Хэйбүн Гүртү Балгас”, домог

Нэг. Домгийн агуулга ба үзэл санаа

Зохиогчоос зохиол бүтээлдээ домог, үлгэр зэргийг татан оруулж хэрэглэдэг нь зохиол дахь хүн, газар орон, хэрэг учрын нэр гарал, учир шалтгаан зэргийг тодлон тайлбарлах шаардлагаас болсон төдийгүй тэр нь зохиолын хэрэг явдлын эсгэлт

\* БНХАУ, Бээжингийн Төвийн Үндэстний Их Сургуулийн Монгол хэл, утга зохиолын салбар

байршуулалт, утга санааны дүвийлгэлээс болсон байж болох мөртлөө зохиолын өнөр амтыг өтгөрүүлж, урлагийн төвшинг дээшлүүлэх үйлдэл хэрэгцээтэй байдаг.

“Утга зохиол нь амьдралын төрдөс гэдэг боловч тэр нь зохиогчийн оюун санаа ба ур чадвараар туурвин бүтээдэгийн учир, утга зохиол нь амьдралын үзэгдлийн дөхөмхөн зэрэглэл овоорол төдий биш, харин зохиогчийн үзэл ухамсар гүн шингэсэн оюун санааны нөлөөлөх хүчин бүхий бүтээл байдаг.”<sup>1</sup> Иймээс зохиогчоос өөрийн үзэл санааны илрүүллийн шаардлагаа үндэслэж, зохиолдоо элдэв өнөр амт бүхий зүйлсийг эшлэн хэрэглэдэг.

“Утга зохиолд домог туулийн онгод оршуулах нь зөвхөн уншвартай, харин сонирхолтой болгох гэсэн байгаа биш”. Харин “домог туульс бол нэг зүйлийн үндэстний үзэгдэл-үндэстний зориг сүлдийн хамгийн идэргүүн жавхаат дуулал болно. Онгод оршуулж байгаа мэт ямар нэгэн үед хүрвэл домог туульс... үндэстний сүг сүнснийг дуудан сэрээж, зориг сүлдийг даллан босгох хүчинтэй болдог”-оос л болсон юм. Тэгээд домог ба үнэнийг соливцуулан бичсэн нь Га.Шаравжамцын найрууллын нэг онцлог болсон байна.

Үндэстэн угсаатны өөдлөл уруудал, бүлгэмдэл нягтралтай холбогдсон домогт “Баарин гүүр” найруулал дахь “Шар уст чулуун гүүр” гэж анх нэрлэж байснаасаа “Баарин гүүр”-ийг бариж, Энх Амгалан хааны зарлигаар шинээр нэрлэн дуудах болсон тухай домог болон найруулал “Шанду Хэйбүн Гүртү Балгас” дахь монголчууд хун галууг агнахаа больсон домог, Тогоон-Төмөр хааны зүүд, “зудтай зунтай хорвоо” найрууллын “эрний жавхаат нийслэл Банкок” дахь эрлэг хааны монгол хятад үндэстний нүгэлт сүнснүүдийг тостой тогоонд хийсэн домгууд багтаж байна. Хүн зоны эмзэглэл шаналал болон янаг хайрын тухайд “зудтай зунтай хорвоо”-гийн “эртний түүхт Сиям Лаво” дахь “Хүй голын гүүр”-ийн их тэсрэлтэнд амиа алдагсадын хилс сүнсний тухай яриа, “Эртний жавхаат нийслэл Банкок” дахь “Ванбян вангийн орд”-ыг байгуулсан Бувакатсаруу хааны учрал тохиолдлын тухай домгуудыг дурьдаж болно. Одоох нийгэм ахуйн нүсэр хүнд сэдвийн тухай домог, яриануудад “элдэв амьтны үржилт нутаг” дахь улаан эрээн хүзүүт ногоон могой Сун гургуулаас хувирсан гэх яриа болон могой бар хоёрын бэлгийн эрхтэний өргөстэй болсон домгийг жишээ болгож болно.

Эдгээр домог, ардын яриа, зүүд совин зэрэг нь Га.Шаравжамцын найруулал дахь нэгэн ачаалагч бие болсоны хувьд найрууллыг уншвартай хачин сонирхолтой болгосон төдийгүй, найрууллын утга сэдвийг нэн гүн шатанд хүргэж, үзэл санаат чанарыг сайжруулсан байна. “Баарин гүүр”-ийн тухай Энх Амгалан хаан болон нэг монгол өвгөний хооронд болсон яриа жич өвгөний ярисан үгсээс тухай үеийн монголчуудын манжийн ноёрхолд дургүйцсэн, монгол феодал ялзармал ноёрхогчдын манжийн засагт элдэн дагаж байсан номой дорой шинжийг илчлэн тусгасан бол Тогоон-Төмөр хааны зүүд-төмөр соёотой бодон нь хот дотор орж хааны өөд довтолсон нь төрөө алдахын ёр болжээ. Гэтэл хаанаас сэрэмж авсангүй учир хожим хойно нь Жү Юань Жаньд төрөө

---

<sup>1</sup> Б.Сүх: “Монгол уран зохиолын урлахуй ухаан”, Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо, 2001 оны 7 сар, Р.210.

алдаж, “Жаргалд ташуурч, архинд орж, явдал журмыг алдсан” гэмшил хоцроосон байна. Энэ нь Тогоон-Төмөр хаан чанагшлан Юаний төрийн хаадын эрх жаргалд хэтэрхий согтуурснаас төрөө алдсан ялзармал чанарыг тусгасан байна. Үндэстний мандал мөхлийн хувь тавиланд санаа эс тавиж, нүдэн өмнөх жаргал цэнгэлд сэтгэл ханан, монгол түмнийхээ хувь тавиланг нэг зуунаар биш, нэг өдөр л төдий ч санаа болдоггүй түүхт үнэн нь домог гэх энэхүү ачаалагч биеэр дамжин амьдлаг бодтой илэрч чадсан бол “*Эртний жавхаат нийслэл Банкок*” дахь домог-эрлэг хаанаас эл үндэстний нүгэлт сүнсийг тостой тогоонд хийсэнд монгол үндэстэн өөр зуураа өрсөлдөж, харилцан татаж унасаар эцэстээ хэн ч гарч чадсангүй байхад хятадууд харилцан дэмжилцэж эцэстээ олонх тооны хүмүүс гарч явсан нь ил тод харьцуулал болж, монголчуудын багаараа хамтран ажиллах тухай ойлголт дутмаг, бүлгэмдэл нягтралыг эрхэмлэдэггүй архаг гэмийг илчлэн шүүмжлэхэд үйлчилсэн байна. Иймэрхүү ачаалагч биеэр дамжин илэрсэн хүүрнэл буюу шүүмжлэл нь түүхэн үнэний хуулбар буюу шууд шүүмжлэл хийх байдлыг өөрчилж, түүхэн үнэн буюу шүүмжлэлийг бодтой мөртөө шүүмжлэлийг далд чанартай болгож, зохиогчийн үзэл сэтгэлгээ нь ил уудлалаас зайлсхийж чадсан байна.

Эдгээр домог, үлгэр яриагаар илэрсэн үндэстнийхээ алс ирээдүйн тухай санаашрал болон бүлгэмдэл нягтралыг эрхэмлэж, хамтаар урагш дэвшихийг уриалсан санаа нь зохиолын үндэстний шинжийг нэн тод товгор болгож зохиогчийн үндэстний сэтгэлгээг улам ил тодорхой болгосон байна.

“Эртний түүхт Сиям лаво” дахь “Хүй голын гүүр”-ийн тухай ярианд Хүй голын гүүрийн тэсрэлтэнд эндэгдэн үхсэн хилс сүнснүүд нь одоо болтол тэнүүчилсээр бөгөөд бут биеээрээ илрэн буудлын үүдийг тогшин явдагийг бичсэн байна. Энэ нь агуулгын хувьд зэвүүн сүрхий болсон шиг байвч үнэндээ тэдгээр нь дайны хөлд дайрагдсан хилс ардууд болох учир тэд нарийн сүнс нь хүртэл орох газаргүй тэнүүлчин болсноос дайн дажины хүн ардад учруулсан гай зовлонг таньж мэдүүлэх гэсэн зохиогчийн санаа зорилгын илрүүлэл болж найруулалд орж ирсэн байна. Үүний эсрэгээр “*Эртний жавхаат нийслэл Банкок*” дахь Ийтайн вант төрийн үеийн Бувакатсаруугаас үхлийн аюулаас амь бөх үлдэж, нэгэн дагина шиг гоо хүүхэнтэй амраглан суусан гайхамшигт тохиолдлыг дуртгахын төлөө барьсан “*Ванбайн вангийн орд*”-ын домог бол янаг хайрын тухай хүсэл амилал болж илэрсэн байна. Энэ хоёр домог, үлгэр яриа нь зохиогчийн найруулалд нэг ачаалагч биеийн хувиар оролцохдоо хүний сэтгэлийн гүн дэх шаналал догдлолыг илрүүлэн хөндөж, уншигчийг гүн бодол руу хөтөлсөн үйлдэл үзүүлжээ.

“*Элдэв амьтны үржилт нутаг*”-т “*Сун гургууль тэнгэрийн дууг дагаж дуугарч амжихгүй бол могой болдог*” гэх үлгэр болон хурмаст тэнгэр могой бар хоёрыг зохиохдоо үржлийг нь хязгаарлах гэж бэлэг эрхтэнийг нь өргөстэй болгосон домог нь яг сайхан одоогийн нийгмийн бодит байдал-хүний хорлол устгалаас ан араатны цөөрөл устал болон байгаль ахуйн эвдэгдэл, үүний эсрэгээр хүн амын шүүрүүн нэмэгдлийг татан гаргаж, үнэндээ тэдний (могой бар мэтийн амьтан) “үржлийг харшилсан өргөс нь

тэдний бэлгэ эрхтэн биш харин хар толгойтон”<sup>2</sup> болно гэх санаагаа дам дохиж, монголын хувьд “хурмастын хар ташуур хорт могойн өргөс нь шарын шашин билээ”<sup>3</sup> гэдгийг илчлэн задлахад үйлчилж, найрууллын агуулгыг баялагжуулсан төдийгүй зохиогчийн үзэл санаа хүсэл зорилтын илрүүллийн гүүр болсон мөртөө нийгэм ахуйн өөрчлөлт хувьсалтыг дагаж хүний үзэл ухамсар сэтгэлд ч хувиралт гарч, дээрхээ бялдуучлах, ноёнч сурталын буруу байсан ч аялдан дагалцах дуун хоолой авалцаж байгаа хэв бус сурталын хүнд ноцтой байдлыг илчилсэн нь мөн эдгээр үлгэр домгийг эшлэсний үндсэн зорилго болно. Гэхдээ найруулал дахь үлгэр домгийн тэнгэрийн дуун нь байгалийн зориг санааг бэлэгдэж, хүн амьтан оршин амьдрахад заавал байгалийн зориг санаанаас тэрслэж болохгүй учир “байгаль-хөх усан бөмбөрцөгтэйгээ дуун хоолой авалцаж амьсгаа нэгтэй байх хэрэгтэй”<sup>4</sup> гэх үзлээ дурьдсан нь одоогийн хүн төрөлхтөний хамтаар нүүрдэн тулгарч бүхий байгаль орчны эвдэгдэлийн асуудалд чиглэсэн алс хэтийн ач холбогдол бүхий үзэл санаа илэрч буй. Энэ нь зохиогчийн монгол хүний байгалтай харьцах гүн ухааныг сайн мэдэрч байсны илрэл гэж хэлж болох юм. Иймээс найруулал дахь тэдгээр олон домог үлгэр ярианууд нь дан ганц найрууллыг уншвартай сонин сэвүүн болгосон төдийгүй тэр нь нэгэн ачаалагч биеийн хувиар зохиогчийн угсаатан, нийгэм ахуй, хүн зон гэх хүнд чихмэй асуудлыг хөндөж, өөрийн үзэлт зорилтоо илтгэхэд үйлчилсэн байна.

Хоёр. Домгийн онцлог шинж

Га.Шаравжамцын “туужист үндэстний ухамсар бол удиртгал, үндсэн хөг буюу утгын сурвалж болж, түүх ба ахуй бол түүний ачаалагч, бодит явц болж байдаг... түүх ба ахуйн зайг шахуулан, цаг ба орчинг нөхцөлдүүлэн бичсэнээр түүний туужис түүхчилсэн домог буюу домогчилсан түүхийн шинжтэй байдаг”. Түүний туужис дахь үлгэр домгуудыг нийтэд нь авч үзвэл хүн төрөлхтөний хүүхэд үеийн бүтээл болох баатарлаг домог үлгэрүүдтэй адливартай байж, агуулга утгын тогтонгүй шинжийг хадгалсан боловч цаг ба газар орны тогтонгуй бус шинжтэй байж, уг хэлбэрийнхэн түм мянган хувилбарын нэгэн шиг харагддаг байна. Туужсын зохиолд хэлцийн орчин нь үлгэр домгийг нэг бэлэгдэл дүр болгожээ. Өөрөөр хэлбэл тэдгээр домог үлгэрүүд нь агуу их монголчуудын баатарлаг түүх, эсвэл тэдний зориг санаа, цог жавхаа, эсвэл үндэстний ховор нандин түүх соёлын өв хөрөнгө, эсвэл ухаан бодлын үр таластыг шингэн хадгалсан эд өлгийн гэх мэтийн үндэстний эрхэм нандин зүйлстэй холбогдох үлэмжийн их утгасын бодит бие дүрс болсон байна. Тэр нь нэг зүйлийн соёлын ачаалагч, соёлын тэмдэг болсоны хувьд бүхий л өгүүллэг туужсын утгыг даац ихтэй болгосон байна. Өгүүллэг туужисдаа үлгэр домгийг хэрэглэсэн нь үндэстний эрч зоргийн нугарал бүдрэл, үхэл үрэгдлийн гунигт ухамсарыг илрүүлж, соёлын зориг

<sup>2</sup>) Га.Шаравжамц “Шанду Хэйбун Гүртү Балгас”, үндэстний хэвлэлийн хороо, 2001 оны 11 сар, 424-р нүүрт.

<sup>3</sup>) Га.Шаравжамц “Шанду Хэйбун Гүртү Балгас”, үндэстний хэвлэлийн хороо, 2001 оны 11 сар, 291-р нүүрт.

<sup>4</sup>) Га.Шаравжамц “Шанду Хэйбун Гүртү Балгас”, үндэстний хэвлэлийн хороо, 2001 оны 11 сар, 39-р нүүрт.

санааны сулрал усталын төлөөний хямралт ухамсарыг харуулсан гэдэг бол түүний найруулал дахь үлгэр, домгууд нь үндэстнийхээ уруудал мөхөл, бүлэгт цогцын ухамсарын доройтол, хүн зоны эмзэг буурай сэтгэл, амь ахуйн оршин тогтнол зэрэгт санаа тавиж, зохиогч утга зохиолоор дамжуулж, үндэстнийхээ гишүүн нэг бүрийг сэхээрүүлэх зорилт, үндэстнийхээ уг удамын холбоо бүхий эрхэм нандин зүйл бүхнээ харж хамгаалах хариуцлагат овор, шинжлэх ухаан техник мэргэжлийн нисэх мэт хөгжилт болон хүний уур чанарын доройтол болсон гунигт ухамсар зэргийг далдаас дохисон байна.

“Боловсон үед хүрч ирээд одооч ухаан хийгээд шашин суртахуунд хавчигдан дайрагдаад эртний домог туульс, хэлбэрийн хувьд доройтох зүгтээ хандсан боловч агуулгын хувьд харин хэзээ ч устахгүй амиллын чанга хүчинтэй байдаг”<sup>5</sup>. “Боловсон нийгэм хэдий энэ бүхнийг, ялангуяа эртний баатарлаг зориг санааг барилал, дүрэмжүүлж... хэн нэгний санаагаар бөмбөрдөх бөмбөг шиг юм болгохыг хүсдэг боловч оюунч чанар домгийг хэзээд орлож чадахгүй, хүн төрөлхтөний муу муухай зүйлстэйгээ тэмцэл хийдэг зориг санааг устгаж чадахгүй юм”<sup>6</sup>. Энэ нь яг сайхан зохиогчийн тус найруулал “*Шанду Хэйбүн Гүртү Балгас*”-т илэрсэн домгуудын тухай тайлбар гэж хэлж болно. “*Шанду Хэйбүн Гүртү Балгас*” найрууллын түүвэр нь хорьдугаар зууны сүүлч, хорин нэгдүгээр зууны эхэн үед бичигдсэн учир монгол үндэстний одоох байдал-хөдөлмөр үйлдвэрийн хоцрогдол, залхуурал, архидалт газар авсан, шинжлэх ухаанаас хол зайдуу, үг хэл үсэг бичгээ үл хүндэтгэх, байгал орчны эвдэгдэлд санаа тавихгүй зэрэг хүнд ноцтой асуудлын тухай сэтгэл зовож байгаа үзэл бодол нь илхэн харагдна. Иймэрхүү олон хүнд нүсэр асуудалд хандуулж “21-р зуунд бид яах бэ?” гэх асуулт дурьдаж, “мэдлэгийн аж ахуйгаар үүд өрхөө сэхсэн 21-р зуун бол аль ч угсаатны ямар ч хэлэнд бүр эрх тэгшээр ханддаг шинжлэх ухааны үүдэн бүтээлтийн шинэ эрэн болохоос биш, бэлчээрээ сольж отор шилждэг шиг үндэстний их нүүдлийн цаг үе биш юм”<sup>7</sup> гэж зохиогчоос өөрийн үзэлт танилтаа илрүүлэх гэсэн бол энэхүү үзэлт танилтаа найрууллаар дамжин илтгэхэд ачаалагч бие болсон үлгэр домгууд нь ч цаг үеийн онцлог шинжид нөлөөлөгдсөн байдаг. Даруй найруулалд орсон тэдгээр үлгэр домгууд нь эртний баларлаг үеийн домог туульс шиг монголчуудын усны тунгалаг, өвсний соргогийг даган нүүдэллэн, нар мандахаас наран шингэх хүртэлх хязгааргүй уудам нутагт дураар жарган цэнгэдэг байсан буюу аль эртний домог тууль, ёгт үлгэр шиг орон зай, цаг үеийн балархай буюу тогтонгуй бустай адилгүй байдаг. “*Шар уст чулуу гүүр*” нь Энх Амгалан хааны үед, монголчуудын хун галууг агнахаа больсон тухай домог нь Тогоон-Төмөр хаанаас сүүлээрх домог байж, Тогоон-Төмөр хааны зүүд нь Жү Юань Жангийн бослогын үед, “*Ванбайн вангийн орд*”-ын домог нь эрт Аюутиа вант төрийн хорьдугаар үеийн хаан Бувакатсарогийн үед гэх мэтчилэн цаг, орон, хүн нь харьцангуй тодорхой бөгөөд тогтонгуй байж, түүх ахуйн үнэн мөнийг

<sup>5</sup>) Цэнгэлт: “*Зууны уулзар дахь монгол уран зохиолын үзэгдэл шүүмжлэл*”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2001 оны 12-р сар, 223-р нүүрт.

<sup>6</sup>) Га.Шаравжамц “*Шанду Хэйбүн Гүртү Балгас*”, үндэстний хэвлэлийн хороо, 2001 оны 11 сар, 44-р нүүрт.

<sup>7</sup>) Га.Шаравжамц “*Шанду Хэйбүн Гүртү Балгас*”, үндэстний хэвлэлийн хороо, 2001 оны 11 сар, 67-р нүүрт.

тооцож тэмдэглэхэд үйлчилсэн нь цаг үеийн онцлогоор ил тод болсон мөртөө тариалах малжих хоёр соёлын мөргөлдөөнөөс болсон нүүдэл соёлын доройтолын бодит ахуйн домог туульст үзүүлсэн нөлөө тусгал-хэлбэрийн хувирлыг харуулж байна. Энэ нь “монгол домогт зохиомол шашны үзэлт танилт ба ойр, орчин үеийн хүмүүсийн ойлголт сэтгэлгээ нь хүртэл маш гүн нэвчсэн байдаг. Ялангуяа бурхан шашны орчлон ертөнцийн тухай танилт тайлбар жич сүүлч үеийн хүн нийгмийн тухай үзэл сэтгэлгээ нь тун тодорхой харагдаж байдаг”<sup>8</sup>-аас болсон байж болох юм. Гэвч, “боловсон нийгэм” нь хэдийгээр домог туульсыг хүлж хүшисэн гэдэг боловч түүний зориг санаа нь амархан шилжин устахгүй учир Га.Шаравжамцаас найруулалдаа үлгэр домгийг зоригтой хэрэглэн, тэр олон үлгэр домгуудаа найрууллын эчинээ гүн санаа ахуйд үйлчлүүлж, мухардал бухимдалын цаг үе дэх монголчуудынхаа баатарлаг сүг сүлдийг дуудан сэрээх, доройтсон соёлоо мандуулах урай дуун болсон байна. Энэ нь яг сайхан зохиогчоос “*Шанду Хэйбүн Гүртү Балгас*” найрууллын түүвэр дэхь “домог туульс хийгээд үндэстний зориг сүлд” зохиолдоо “домог шиг юм бичье л гэж би боддог, бичсэн маань тэгээд маргааш нь домог тууль байгаасай гэж хүсдэг” гэж ярьсан шиг найруулал нь домгийн тухай олон эшлэл хэрэглэлтэй байж, тэдгээр домгуудын тухай эшлэл хэрэглэл нь найруулалын бичлэгийн арга хэлбэрийг баялагжуулж, найруулал дахь ачаалагч бие нь дан ганц хэрэг үзэгдэлээс олон тал тийш хөгжиж, үлгэр түүх, домог яриа гэх мэтийн ачаалагч биеэр дамжин, өөрийн үзэл сэтгэлгээ илтгэсэн нь шинэ нэгэн туршич болсон бөгөөд домог, үлгэрүүд нь мөн ч зохиогчийн үзэл сэтгэлгээний илрүүллийн өвөрмөц онцлог шинж болсон байна.

Ерөнхийд нь үзвэл, Га.Шаравжамцын найруулал нь домог, үлгэр, зүүд совин гэх мэтийг өргөнөөр эшлэж хэрэглэснээр үзвэл зохиогчоос ямар нэгэн шидэт хүчин оршиж байгааг итгэж байх мөртөө хүүрнэн ярьж байгаа хэрэг үзэгдлийн түүхт шинж хийгээд домог шиг гүн зузаан агуулга санааг агуулж байдгийг дэлгэн ярих гэсэн бөгөөд түүнийхээ итгүүлэх хүчинг гүнзгийрүүлэхээр чармайсан нь илхэн байна. Домгуудыг эшлэж хэрэглэсэн нь мөн домог хийгээд одоох ахуй дахь үйл хэргийн дотоод харьцаа холбоотой байх юм уу, эсвэл ямар нэгэн шидэт хүний оршихуйгаар одоох хэрэг үзэгдлийг тайлбарлаж, шүүмжлэх гэсэн оролдлого мөн гэж хэлж болно. Даруй бурхан сахиусын хараа цэг буюу домгуудыг хэрэглэсэн нь тэд нэрийн шидэт хүчинг ашиглан, өөрийн эгэл ерөмдөг хүний зогсоцоос түүхийг дахин шүүх хийгээд одоох бодит байдлыг хүүрнэн өгүүлэхдээ үйлчлүүлсэнд оршино. Мөн үлгэр үйл явдлын цааш хүүрнэхийн арга зам болсон бөгөөд зохиогчийн зохиолоо туурвихын нэг хэвшил тогтолцоо болсон гэж хэлж болмоор байна.

---

<sup>8)</sup> Гэ.Намжил: “Монгол домгийн харьцуулсан судлал”, үндэстний хэвлэлийн хороо, 2001 оны 6-р сар, 16-р нүүрт.

## НОМ ЗҮЙ

1. Ван Мандуга: “Утга зохиолын онолын удиртгал”, Үндэстний хэвлэлийн хороо, 1999 оны 4-р сар.
2. Сүйгэ: “Монгол уран зохиолын түүх”, Лиё Нин мужийн үндэстний хэвлэлийн хороо, 1995 оны 6-р сар.
3. Б.Сүх: “Монгол уран зохиолын урлахуй ухаан”, Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо, 2001 оны 7 сар.
4. Б.Гэрэл, Чулуу: “Утга зохиолын онолын хураангуй”, Өвөр Монголын багшийн их сургуулийн хэвлэлийн хороо, 1989 оны 4-р сар.
5. Саран-Гэрэл: “Тууль Жангар ба Монгол соёл”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1998 оны 12-р сар.
6. Тэнгис найруулан зохиосон “Монгол баатарын тууль ба эртний тал нутгийн боловсон”, Үндэстний хэвлэлийн хороо, 2001 оны 11-р сар.
7. Гэ.Намжил: “Монгол домгийн харьцуулсан судлал”, үндэстний хэвлэлийн хороо, 2001 оны 6-р сар.

## SUMMARY

Essays by Ga.Sharavjamts are enriched broadly by myths, tales and dreams. Analyzing his works, it is clear that he has strong feelings and beliefs and tried the readers to be believed in its deep historical and mythical contents.